



## ЦУС СЭЛБЭЛТ СУДАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Цусны донор, донор зохион байгуулагчид олгох урамшууллыг  
шинэчлэн батлах тухай

Монгол улсын Донорын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 22 дугаар зүйлийн 22.2 дах заалт, Удирдлагын зөвлөлийн хурлын 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цусны донорт олгох урамшууллыг нэгдүгээр хавсралтаар, донор зохион байгуулагчид олгох урамшууллыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Жил бүрийн цус, сийвэн цуглуулах төлөвлөгөө, батлагдсан төсөвт багтаан донорт олгох багцын үнийг тогтоохыг Стратеги төлөвлөлт, санхүү бүртгэлийн албаны дарга /Ч.Батболд/-д даалгасугай.
3. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч /Ё.Улсболд/, Ахлах нягтлан бодогч /Ө.Бат-эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалыг 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /Д.Амар/-т даалгасугай.
6. Уг тушаал гарсантай холбогдуулан төвийн захирлын 2008 оны А/56 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
 2019 оны 03 дүгээр сарын 29-ний өдрийн  
 А.Т. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Цусны донорт олгох урамшуулал

№	Цус өгөлтийн төрөл	Өгөлтийн тоо	Бэлэн мөнгө	Донорын багц	Тайлбар
1	Шинэ донор	1	-	+	
2	Байнгын донор	2-3	1000	+	
3	Байнгын донор	4-34	2000	+	
4	Хүндэт донор	35-аас дээш	3000	+	
5	Сөрөг донор	хамаарахгүй	3000	+	
6	Сийвэнгийн донор	хамаарахгүй	3000	+	
7	Эсийн донор	хамаарахгүй	18000	+	Эс аваагүй тохиолдолд сийвэнгийн донороор тооцно.
8	Явуулын цус цуглуулалт	хамаарахгүй	-	+	
9	Дуудагдаж ирсэн донор	хамаарахгүй	5000	+	Ажлын бус цагаар дуудагдсан тохиолдолд хамаарна.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2019 оны 03 дүгээр сарын 29-ний өдрийн  
АИЖ-тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Донор зохион байгуулагчид олгох урамшуулал олгох

№	Элсүүлсэн донорын тоо	Олгох урамшуулалын дүн
1	60-80 хүртэл донор	15 000 төгрөг
2	80-100 хүртэл донор	20 000 төгрөг
3	101–ээс дээш донор	25 000 төгрөг

Тайлбар: Урамшуулалыг тухайн өдрийн цусаа бэлэглэсэн донорын тоогоор тооцно.